



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 5 сарын 13 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт,
хөндлөнгийн хяналт хийх төрийн бус
байгууллагуудыг бүртгэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.13 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам”-ын 2.4 дэх хэсгийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1.“Мидас” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Шүхэр нэгдсэн бодлогын ерөнхий зөвлөл” ТББ, “Монголын багш, эцэг эхчүүдийн холбоо” ТББ, “Бодлогод залуусын хяналт” ТББ-уудыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх төрийн бус байгууллагаар бүртгэсүгэй.

2.Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх төрийн бус байгууллагуудад холбогдох хууль, журамд заасны дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг сонгуулийн хороодод зөвлөсүгэй.


3.Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийхээр бүртгэгдсэн төрийн бус байгууллагуудад үйл ажиллагаандаа сонгуулийн тухай хууль тогтоомжийг чанд сахиж, коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, журам, мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР



0000115